



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Жуулчин тээврийн зөвшөөрлийг
шинэчлэн олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/469 дугаар захирамж, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улсын дугаарын хязгаарлалтгүйгээр нийслэл хотын авто замын хөдөлгөөнд оролцох 8-аас дээш хүний суудалтай жуулчин тээврийн хэрэгсэлд олгох зөвшөөрлийн шинэ загварыг нэгдүгээр, жуулчин тээврийн хэрэгсэлтэй байгуулах гэрээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг зөвшөөрлийг "Жуулчны авто тээврийн үйлчилгээний ерөнхий шаардлага MNS 5231 2003" стандартын шаардлага хангасан, "Жуулчин" наалт бүхий тээврийн хэрэгсэл эзэмшигчтэй гэрээ байгуулан олгож байхыг Жуулчны аюулгүй байдал, сургалт хариуцсан мэргэжилтэн /М.Баасандорж/-д даалгасугай.

3. Тээврийн хэрэгсэл эзэмшигч аж ахуйн нэгж, хувь хүнээс гэрээний дагуу зөвшөөрлийн хураамж 5000 төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд шилжүүлсэн байдалд хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д зөвшөөрсүгэй.

4. Жуулчин тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгох тухай Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2015 оны А/47 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БАТСҮХ

1150500025



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

Зөвшөөрөл

20 ... оны ... дугаар сарын ... -ний өдөр

№ 30


Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/469 дугаар захирамжийг үндэслэн
..... улсын дугаартай маркын
жуулчин тээврийн автобусанд дугаарын хязгаарлалтгүйгээр нийслэл хотын авто
замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрлийг олгов.

ДАРГА Д.БАТСҮХ


Энэхүү зөвшөөрөл нь 20/...-ныг дуустал хүчинтэй.

УЛСЫН ДУГААРЫН ХЯЗГААРЛАЛТГҮЙГЭЭР НИЙСЛЭЛ ХОТЫН АВТО ЗАМЫН
ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХ ЖУУЛЧИН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ОЛГОХ
ЗӨВШӨӨРЛИЙН ЗАГВАР



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2017 оны 01 сарын 18 өдрийн А/09
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2017 оны 04 сарын 18 өдрийн А/09
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



УЛСЫН ДУГААРЫН ХЯЗГААРЛАЛТГҮЙГЭЭР НИЙСЛЭЛ
ХОТЫН АВТО ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЖУУЛЧИН
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЭЗЭМШИГЧТЭЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

2017 оны ... сарын ... ны өдөр

№..

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1. Энэ гэрээ нь Монгол улсын Иргэний хууль, Авто тээврийн тухай хууль, Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм, "Жуулчны авто тээврийн үйлчилгээний ерөнхий шаардлага" MNS 5231 2003" стандарт болон авто тээврийн салбарт нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллана

Хоёр. Гэрээний хугацаа

1. Гэрээг 2017 оны ..-р сарын .. ны өдрөөс эхлэн 2017 оны ..-р сарын .. ны өдөр хүртэл байгуулав.
2. Гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
3. Гэрээний биелэлтийг 11 дүгээр сард НАЖГ-т ирүүлнэ.

Гурав. НАЖГ-ын эрх үүрэг

1. Жуулчин тээврийн хэрэгслийн үйлчилгээний соёл, стандартыг хангуулах талаар мэргэжил арга зүйн сургалт, зөвлөмж өгөх, дутагдал доголдлыг засуулах
2. Жуулчин тээвэрлэгчийг ур чадвартай, гадаад хэлний зохих шатны мэдлэгтэй байхыг шаардах
3. Авто тээврийн үндэсний төвтэй байгуулсан гэрээ, TOURIST-ЖУУЛЧИН наалт, таних тэмдгийг үндэслэн улсын дугаарын хязгаарлалтгүйгээр хотын төв замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрлийг олгоно.
4. Зөвшөөрлийн маягтын хэвлэлтийн зардал 5000 төгрөгийн хураамжийг зөвшөөрөл олгогчоос хураана.
5. Жуулчин тээвэрлэлтийн талаарх санал гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх

Дөрөв. Тээвэрлэгчийн эрх үүрэг

1. Авто тээврийн үндэсний төвтэй байгуулсан гэрээ, TOURIST-ЖУУЛЧИН наалт, таних тэмдэг, мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй байна.
2. Жуулчдад цаг хугацааг сайн баримтлан хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган соёлтой үйлчилгээг хүргэх
3. Зөвшөөрлийн маягтын хэвлэлтийн зардал 5000 төгрөгийн хураамжийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд тушаасан байна.

Гэрээ байгуулсан

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрыг төлөөлж:

.....

.....